



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

194 /194/ 2021.12.06

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

2007 он.

Батлан хамгаалахын сайдаар Ж.Батхуяг томилогдов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ -4	🌧️ -20

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,852.0	2,854.0
EUR 🇪🇺	3,230.0	3,237.0
CNY 🇨🇳	447.0	448.0
RUB 🇷🇺	39.20	40.20
JPY 🇯🇵	25.00	25.15
KRW 🇰🇷	2.41	2.42

ЗУРХАЙ

2021.12.06 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 02/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН НЭГ ЦАГААН ХАР ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал: Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингэх: 08.26-17.00

Барилдлага:

Рашаан Шүтэн барилдлага:

Мунхрахуй Суудал: Ус

Аргын тооллын 12 сарын 6, Сумъяа гараг. Билгийн тооллын 2, Суулга одтой шар хулгана өдөр. Өдрийн наран 8 цаг 26 минутад мандан, 17 цаг 00 минутад жаргана. Тухайн өдөр бич, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Энэ өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамырыг сэргээх, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, улааны үйл, хур оруулах, дархны үйлд сайн.

Төлөг тавих, морь уралдуулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв байгууллагуудын дунд жил бүр уламжлал болон явагдаж ирсэн "Засгийн газрын цом" спортын тэмцээн өнгөрсөн долоо хоногт амжилттай зохион байгуулагдаж өчигдөр аваргаа тодрууллаа.

Дөрвөн төрлөөр өрсөлдсөн уг тэмцээний шатрын эрэгтэй төрөлд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, эмэгтэй төрөлд Эрчим хүчний яам, ширээний теннисний эрэгтэй, эмэгтэй төрөлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, гар бөмбөгийн эрэгтэй төрөлд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, эмэгтэй төрөлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сагсан бөмбөгийн эрэгтэй төрөлд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, эмэгтэй төрөлд Эрчим хүчний яам алтан медалийг хүртлээ. Харин тэмцээний нийлбэр дүнгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газар тэргүүлж "Засгийн газрын цом"-ын эзэн болсон юм.

Ташрамд дурдахад гурван өдөр үргэлжилсэн тус тэмцээнд нийт 14 байгууллага оролцсон бөгөөд анхны таван яам байгуулагдсаны 110 жилийн ойн хүрээнд болсноороо онцлог байлаа.

“МОНГОЛ ОРОН БАДАРТУГАЙ” ТОГЛОЛТ БОЛЛОО

Монголын мэргэжлийн урлагийн ууган байгууллагуудын нэг, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон цорын ганц урлагийн байгууллага болох Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын 89 дэх жилийн өвөл цагийн нээлтийн тоглолт "Монгол орон бадартугай" нэртэйгээр энэ амралтын өдрүүдэд үзэгчдийн халуун алга ташилтад дунд амжилттай болж өнгөрлөө.

2021 онд тус чуулгын уран бүтээлч хамт олон цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жил, Ялалтын баярын Хүндэтгэлийн тоглолт болон бусад уран бүтээлүүдээ цахим хэлбэрээр үзэгчдийн хүртээл болгож байсан бол энэ удаа өвөл цагийн нээлтийн "Монгол орон



бадартугай" хүндэтгэлийн тоглолтоо улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу 50 хувийн дүүргэлттэйгээр 3 дугаар тундаа хамрагдсан ард иргэд, цэргийн алба хаагчдад үнэ төлбөргүйгээр толилууллаа. Бадрангуй дуулал, омогшим бүтээлээр ард иргэд, цэрэг дайчдаа соён гэгээрүүлсээр ирсэн чуулгын түүхт 90 жилийн ой ирэх 2022 онд тохиох бөгөөд ой угтсан өрнүүн ажил энэхүү тоглолтоор эхэлж байна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 373,339 +327	ЭДГЭРСЭН 537,073	НАС БАРСАН 1,941 +3
----------------------------------	---------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6555 +110	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 59	ЭДГЭРСЭН 6369
------------------------------	---------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 264,932,878
Эдгэрсэн Нийт: 238,491,434
Нас барсан Нийт: 5,243,348


цаг үе, үйл явдал

“ТАМХИЧИН БИШ ТАМИРЧИН БОЛЦГООЁ”

Зэвсэгт хүчний 032 ангийн соёл хүмүүжлийн алба “Тамхичин биш тамирчин болцгооё” уриатайгаар сарын аяныг өрнүүлээ. Аяны хүрээнд бие бүрэлдэхүүнд БЗД-ийн Улаан загалмайн ажилтан Б.Нандинцэцэг “Тамхины хор уршиг хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нь” сэдвээр яриа таниулга хийв. Түүнчлэн “Тамхины хяналтын тухай хууль”, тамхины хор уршигын талаарх мэдээлэл, ухуулга сурталчилгааны материалыг салбаруудын мэдээллийн самбарт байршууллаа.

Мөн бие бүрэлдэхүүний дунд тамхинаас татгалзан эрүүл амьдралын хэв маягт шилжихийг уриалан “Цахим гүйлт”-ийн уралдааныг зарлан явуулж, эхний 10 байрыг шалгаруулан ангийн цахим хаягт байршуулан, тэдний идэвх чармайлтыг сурталчилсан юм. Цахим гүйлтийн уралдаанд эрэгтэйчүүдээс тэргүүн ахлагч Б.Баттулга 15,8 км, эмэгтэйчүүдээс ахлагч Ш.Эрдэнэчимэг 37,7 км замыг туулан эхний байруудад шалгарч, 3 хоногийн цалинтай чөлөөгөөр шагнагдлаа.

Хугацаат цэргийн алба



хаагчдын дунд “Тамхи таны амьдралыг сорно” сэдэвт гар зургийн уралдааныг зарлан дүгнэж, ХХТР-ын байлдагч Б.Сод-Эрдэнэ хамт олноо манлайлан тэргүүн байр эзэлж, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ХҮРЭЭНД ...

Байлдааны гавьяаны улаан тугийн болон Алтан гадас одонт БНМАУ-ын маршал Г.Дэмидийн нэрэмжит Зэвсэгт хүчний 186 дугаар анги 2021 оны 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчидтай мэдээлэл сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажлыг чанартай зохион байгуулж байна.

Тодруулбал, өнгөрөгч 11 дүгээр сард мотобуудлагын батальон, артеллерийн дивизион, танкийн рот, зенит артеллерийн батареин хугацаат цэргийн алба хаагчдад танин мэдэхүйн болон улс эх орон, дэлхий дахинд болж буй шинэ мэдээ мэдээллээр хангах,



цэргийн алба хаагчдын бусдыг сонсох болон ярианы чадварыг хөгжүүлэх зорилгоор өдөр бүр 2 цэргийн алба хаагч мэдээлэл хийж байхаар мэдээллийн цагийн хувиар гарган ажиллаж байна.

Хуваарийн дагуу шинэ долоо хоногт мэдээлэл танилцуулах цэргийн алба хаагчдын тодотголыг Баасан гарагт хийж, танилцуулах мэдээллийг улс, эх орон, дэлхий дахин болон хугацаат цэргийн алба хаагчдын санал хүсэлтэд нийцсэн мэдээллээр бэлтгэв. Арваннэгдүгээр сарын 11-нээс энэ сарын 3-ныг хүртэл нийт 30 цэргийн алба хаагч тус тусын сонгож авсан сэдвийн хүрээнд мэдээлэл танилцуулга хийлээ.



МЭДЭЭЛЭЛ ХИЙСНЭЭР ОЛОН ЗҮЙЛД СУРАЛЦАЖ БАЙНА

Мэдээлэл танилцуулсан цэргийн алба хаагчдын төлөөлөл МББ-ы Имбр-ын байлдагч Б.ГАННЭМЭХ:

-Миний хувьд Орхон аймгийн Баян-Өндөр сумаас цэргийн албанд татагдан ирсэн. Иргэнийхээ үүргийг биелүүлэн, эх орныхоо өнцөг булан бүрээс ирсэн олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцэн хугацаат цэргийн алба хааж байгаадаа баяртай байна. Аливаад хандах хандлага, тэсвэр хатуужил, хүнээс үг дуулж сурахаас эхлээд олон зүйлд суралцаж байна. Би “Мэдээллийн цаг”-ийн хуваарийн дагуу Имбр-ын соёл хүмүүжлийн зааварлагч дэслэгч Билгүүнтэй хамтран “Монгол орон дахь эмийн ургамал” сэдвээр мэдээлэл бэлтгэн боловсруулж түүнийг энэ сарын 2-ны өдөр онжавууддаа танилцуулсан. Ийнхүү бусдадаа мэдээлэл хийснээр маш олон давуу талыг бий болгож байна. Тухайлбал, мэдээ мэдээллийг хаанаас олж, хэрхэн боловсруулахаас гадна түүнийгээ бусдад яаж хүргэх талаар суралцаж байна. Үүний зэрэгцээ өдөр тутмын шинэ мэдээ мэдээллүүдээс хоцрогдохгүй байх, эмх цэгцтэй ярьж илтгэх урлагт суралцах, өөрийгөө зөв илэрхийлэх, хамт олонтойгоо

зөв боловсон харьцаж, харилцан ойлголцож сурах, чөлөөт цагаа өөрт болон хамт олондоо үр дүнтэй ашиглан өнгөрүүлэх, бусдын үгийг сонсож сурах, бусдаас болон өөрөө олж авсан



мэдээллээ цааш түгээх, түүнийгээ дадал зуршил болгон хэрэгжүүлэх гэх мэт маш олон давуу талыг дурдаж болно. Мэдээлэл хийж хамт олонтойгоо халуун дулаан яриа өрнүүлэх нь биднийг эвсэг, нийтэч аливаа зүйлсээс хэрэгтэй мэдээллээ олоод авчихдаг болгож байгаа нь таатай байна.

Дэслэгч Б.БИЛГҮҮН

10 ЖИЛИЙН ОЙД БЭЛЭГ БАРИВ

Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн танкийн батальон үүсэн байгуулагдсаны түүхт 10 жилийн ой

тохиож байна. Тус ойг тохиолдуулан хошууч Н.Пүрэвдорж захирагчтай танкийн батальоны бие бүрэлдэхүүн баарын хүндэтгэлийн тоглолтоо өргөн барив.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



30 КМ-ИЙН МАРШИЙГ ХИЧЭЭЛИЙН ГУРВАН ЦЭГЭЭР ...



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу байнгын бие бүрэлдэхүүн, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчидтай тактик тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг үйлдлээ. Маршийг хичээлийн гурван цэгээр төлөвлөн зохион байгуулахдаа

төрөл бүрийн сааданд гарц гаргах, туулах ажиллагаа, дайсны отолттой тулгарах, дайсны отолтоос гарах үеийн ажиллагаа, цэргийн байр зүйн баримжаалал хийх зэрэг сургалтуудыг амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр ангийн захирагчийн тушаалаар цэргийн алба, хичээл сургалтдаа бусдыгаа манлайлсан байлдагч Э.Бүрэнтүмэн, О.Тавилан, О.Мөнх-

Эрдэнэ нарт цэргийн дэд түрүүч цол, байлдагч Б.Бат-Оргил, М.Молор-Эрдэнэ, О.Есүбилэг нарт цэргийн ахлах байлдагч цол тус тус олгосон юм. Мөн байнгын бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагчдын дунд “Олс таталт”, “Цасны сумо” тэмцээнийг амжилттай зохион явууллаа. Олс таталтын тэмцээнд Харуулын салааны бүрэлдэхүүн тэргүүлсэн

бол хугацаат цэргийн алба хаагчдаас дэслэгч Т.Ибраим захирагчтай Инженер сапёрын рот тэргүүлэв. Цасны сумо тэмцээнд Харуулын салааны ахлагч Э.Жавзанжамъян, Саад байгуулах ротын байлдагч М.Баянмөнх нар тэргүүллээ.

Дэслэгч Р.БИЛЭГ



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС

“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)